



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.02.22 № 03/223

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас зарласан НХААГ/20240102152 дугаартай Хөдөлгөөнт эргүүл, хяналтын автомашин /17 ширхэг/ нийлүүлэх тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга хүссэнтэй холбогдуулан дараах тодруулгын хариуг хүргүүлж байна.

№	Оролцогчийн тодруулга	Захиалагчийн тодруулгын хариу
1	Барааг нийлүүлснээс хойш 48 сарын хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлс	Барааг нийлүүлснээс хойш 48 сарын хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн дэлгэрэнгүй жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
2	Урсгал засвар, үйлчилгээний хуваарь	Явсан км болон ашигласан хугацаанд гүйцэтгэх засвар үйлчилгээг ойлгоно.
3	Барааг нийлүүлсний дараах баталгаат хугацаанд хийгдэх байнгын болон урсгал үйлчилгээний (засвар) хуваарь	Нийлүүлэх барааны баталгаат хугацаа болох 2 жилийн хугацаанд хийх байнгын болон урсгал засвар, үйлчилгээний хуваарь гаргаж ирүүлнэ.
4	Үйлдвэрлэсэн он 2022 оноос хойш гэсэн байна. ISO 3779-2009 стандартыг мөрдөх эсэх.	Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй MNS ISO 3779:2010 стандартыг дагаж мөрдөнө. Нийлүүлэх бараа нь 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш үйлдвэрлэгдсэн автомашин байна.
5	Нийлүүлэлтийн хугацаа тендерийн баримт бичиг болон техник үзүүлэлт дээр өөр өөр байна.	Бараа нийлүүлэлтийн эцсийн хугацаа нь тендерийн баримт бичгийн ТШЗ 18.6.8 гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 2.6-д заасны дагуу гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 60 хүртэлх хоногийн дотор нийлүүлнэ гэж заасныг баримтална.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.